



“Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт,
үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан
/УАГ-ГАГ/2017/08-ГА/



НӨАТУС-д бүртгэгдсэн татвар төлөгчдийн тоо нэмэгдэж байгаа ч төлбөрийн баримт олголт хангалтгүй байна.



<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-6
Дарга, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг	БҮЛЭГ 1. Нэмэгдсэн өртгийн албан татварын нэгдсэн цахим системд албан татвар төлөгчид холбогдож байгаа боловч төлбөрийн баримтыг хэвлэж өгөхгүй байна.	
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 НӨАТУС-д бүртгэгдсэн татвар төлөгчдийн тоо нэмэгдэж байгаа ч төлбөрийн баримт олголт хангалтгүй байна.	8
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан	1.2 Илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудын хүсэлтийг хууль, журмын дагуу хянаж баталгаажуулсан байна.	8
Аудитор Д.Должинсүрэн	1.3 Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт хэрэгжиж эхэлснээр НӨАТ-ын төсвийн орлого өмнөх оноос 78.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.	8-10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	БҮЛЭГ 2. НӨАТУС-ыг нэвтрүүлээгүй албан татвар төлөгчдөд хариуцлага тооцож, арга хэмжээ авах эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байна.	
Уг тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn	2.1 НӨАТУС-ыг нэвтрүүлээгүй татвар төлөгчдөд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцох, арга хэмжээ авах журам, заавар, маягтыг батлаж өгөөгүй байна.	9-10
	2.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт, буцаан олголтын талаар татварын маргаан таслах зөвлөлд хандсан асуудал 2015, 2016 онуудад гараагүй байна.	10
	Дүгнэлт	
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот	Зөвлөмж	11
	Тайлангийн хавсралтууд	12
		13-17
2017 оны 9 дүгээр сар		

ТОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НӨАТУС	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшуулалт систем
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
БГБХН	Бүгд гишүүдээрээ бүрэн хариуцлагатай нөхөрлөл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/12 дугаар тушаал, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлийг бууруулах талаар санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтод тавигдах хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ: Дундговь аймгийн Татварын хэлтэс, сумдын татварын байцаагч нарын 2015, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, статистик мэдээ, судалгаа, бусад холбогдох материал, эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхдээ Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу тэргүүлэх аудиторовын баталсан хөтөлбөрийн дагуу аудитын дараах горимыг хэрэгжүүлэв. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, судалгаа хийх;
- Цуглуулсан мэдээ судалгаанд дүн шинжилгээ, харьцуулалт хийх;
- Татварын хэлтсийн ойлголтын алдаа, ойлголтын алдааг илэрхийлж мэдээ, судалгаа гаргуулан харьцуулалт, дүн шинжилгээ хийх
- Аж ахуйн нэгж, байгууллагын цахим төлбөрийн баримт нэвтрүүлэн ажиллаж байгаа нөхцөл байдалтай танилцан, шинжилгээ хийх.

Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн актын холбогдох заалтыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Татварын ерөнхий хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2012-2016 оны төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;

- Засгийн газрын 2009 оны 22 тогтоолоор батлагдсан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”;
- Сангийн сайдын 2009 оны 283 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулах журам”;
- Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах журам”;
- Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн албан татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж баталгаажуулах, гааль, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хөтлөх журам”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, түүний хавсралт”;
- Татварын ерөнхий газрын даргын 2014 оны 101 дүгээр тушаалаар баталсан “Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам”
- Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйл

Аудитын агаарийн ажлын үр дүнд, хугацаа: Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн аудитын багийн аудитор Д.Должинсүрэн 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдрөөс 9 дүгээр сарын 18-ныг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.

Аудитын дүн: Аудитаар нийт 12.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлжээ.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлсэн үеэс эхлэн олон улсын донор байгууллагуудаас байнгын тусламж дэмжлэг авч байсны нэг жишээ нь нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлэх төсөл байсан байна.

1995 оноос хойш Монгол Улсад Олон улсын валютын сан болон Дэлхийн банкны зөвлөхүүд “худалдааны татвар”-ыг нэмэгдсэн өртгийн албан татварт шилжүүлэх талаар удаа дараа зөвлөж, энэ арга хэмжээ нь төсвийн алдагдлыг бууруулах, нийт татварын тогтолцоог бэхжүүлэх чухал арга хэмжээ болохыг тэмдэглэж байжээ.

Ийнхүү 1997 оноос нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлэх төслийг Дэлхийн банкнаас санхүүжүүлж, Олон улсын валютын сангийн мэргэжилтнүүд хуулийн төсөл, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, 1998 оны 01 дүгээр сарын 06-нд “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хууль батлагдаж, мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль мөрдөгдөж эхэлснээс хойш өнөөг хүртэл 31 удаа нэмэлт, өөрчлөлт орж, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай 26 бие даасан хууль гарч, 2006, 2015 онд шинэчлэгдэн батлагджээ

Дундговь аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй татвар төлөгчдийн тоог 2013-2016 оны байдлаар нэгтгэн харуулбал:

Хүснэгт 1. Татвар төлөгчдийн тоо

Тайлант он	ААНОАТ-өөр бүртгэлтэй татвар төлөгч /тоогоор/	НӨАТ төлөгч /тоогоор/	ААНОАТ-өөр бүртгэлтэй татвар төлөгчид эзлэх хувь
	1	2	3
2013	496	208	41.9%
2014	557	265	47.6%
2015	612	263	42.9%
2016	635	196	30.8%
2017 оны 7 сар	658	186	28.3%

Хүснэгт 1-ээс харахад 2017 оны 7 сарын байдлаар нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч 186 бүртгэлтэй байгаа нь нийт ААНОАТ төлөгч хуулийн этгээдийн 28.3 хувийг эзлэж, өмнөх оноос 10-аар буурсан байна.

Жил тутам татвар төлөгчийн тоо өссөн байхад нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн эзлэх хувийн жин 2014 оноос буурсан байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль

шинэчлэгдэн хүчин төгөлдөр мөрдөгдөж 2016 онд өмнөх оноос ААНОАТ төлөгчийн тоо 23 буюу 3.7 хувиар нэмэгдсэн боловч НӨАТ төлөгчийн тоо 25 хувь буюу 67 татвар төлөгчөөр буурсан байна.

Бүлэг 1. Нэмэгдсэн өртгийн албан татварын нэгдсэн цахим системд албан татвар төлөгчид холбогдож байгаа боловч төлбөрийн баримтыг бүрэн хэвлэж өгөхгүй байна.

1.1 НӨАТУС-д бүртгэгдсэн татвар төлөгчдийн тоо нэмэгдэж байгаа ч төлбөрийн баримт олголт хангалтгүй байна.

Аудитад шаардлагатай аж ахуйн нэгж, байгууллагын мэдээ, судалгааг Улсын бүртгэл болон Татварын хэлтсээс авч үзэхэд /хавсралт 1/ зөрүүтэй байгаа учир аудитад ашигласан тоон мэдээллийг Татварын хэлтсийн статистик мэдээллээс ашиглав. Цаашид Татварын ерөнхий хуулийн 13.2.1-д заасны дагуу хуулийн этгээдийн бүртгэлийг цэгцлэхээр Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газраас ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Татварын ерөнхий хуулийн 18.1.8²-д заасны дагуу албан татвар төлөгч стандартын шаардлага хангасан кассын машин, хэвлэх төхөөрөмж хэрэглэх үүрэгтэй.

¹ Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь бүртгэх байгууллагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 14 өдрийн дотор харьяалагдах татварын албанд хувийн хэрэг нээлгэн татвар төлөгчөөр бүртгүүлнэ

² Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэх;

Хүснэгт 2. Татвар төлөгчдийн цахим төлбөрийн системд холбогдсон байдал

Үзүүлэлт	2016 он				2017 оны 7 сар			
	Татварт бүртгэлтэй		Цахим төлбөрт холбогдсон		Татварт бүртгэлтэй		Цахим төлбөрт холбогдсон	
	НӨАТ төлөгч	НӨАТ төлөгч биш	НӨАТ төлөгч	НӨАТ төлөгч биш	НӨАТ төлөгч	НӨАТ төлөгч биш	НӨАТ төлөгч	НӨАТ төлөгч биш
ААН	194	439	189	108	180	472	180	144
Иргэн	2		2	43	6		6	48
Нийт дүн	196	439	191	151	186	472	186	192

Судалгаанаас харахад 2016 онд НӨАТУС-д 342 бизнес эрхлэгчид холбогдсоноос 55.8 хувь буюу 191 нь НӨАТ төлөгч, үлдсэн нь НӨАТ төлөгч бус иргэн, аж ахуй нэгжүүд байна.

Харин 2017 оны эхний хагас жилийн байдлаар НӨАТУС-д өмнөх оноос 10.5 хувь буюу 36 бизнес эрхлэгчээр нэмэгдэж, нийт татвар төлөгчдийн 56.9 хувь буюу 378 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартын шаардлага хангасан бүртгэлийн машин хэрэглэж, цахим системд холбогдон, мэдээллээ төлбөрийн баримтын нэгдсэн системд илгээжээ.

Аудитаар Татварын хэлтэст ирсэн өргөдөл гомдлыг судлан, тэдгээрээс 16 жижиглэн худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын цахим төлбөрийн баримтын хэрэгжилтийг шалгахад барилгын материал борлуулдаг 8 дэлгүүр бэлэн мөнгөний машин хэрэглээгүй, цахим баримт олгоогүй зөрчил илэрлээ. Зөрчлийг арилгуулахаар Татварын хэлтсээс удаа дараа хугацаатай шаардлага хүргүүлсэн ч хэрэгжүүлээгүй байна. Иймд Зөрчлийн тухай хуулийн 11.19-ийн 6.5³-д заасны дагуу арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулах талаар Татварын хэлтэст хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд 2016 онд 342 татвар төлөгч иргэн цахим төлбөрийн баримтын системд 192.6 сая ширхэг худалдан авалтын баримт бүртгүүлсэн байна. Үүнээс 88.6 сая ширхэг сугалааг хуулийн хугацаанд баталгаажуулан 18 удаагийн сугалааны тохирлоор 0.5 сая төгрөгийн хонжворыг 5 иргэн хожиж 2.5 сая төгрөгийн сугалааны урамшуулал авсан байна. /Хавсралт 3/

Худалдаа, үйлчилгээ эрхэлдэг 8 аж ахуйн нэгж, байгууллага стандартын бэлэн мөнгөний машин ашиглаж байгаа боловч зөвхөн хэрэглэгч шаардсан тохиолдолд төлбөрийн баримтыг хэвлэж өгдөг, эсвэл зарим барааны бар код ороогүй гэсэн шалтгаанаар баримт хэвлэж өгдөггүй, дутуу дүнтэй баримт хэвлэж

³ Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

өгдөг зэрэг зөрчил аудитаар илэрсэн. Зөрчлийг арилгуулахаар татварын улсын байцаагч “Ган хайрхан” ХХК-ний Тэмүүлэл дэлгүүр, “Төгрөг мандал” ХХК-ний Аривжих дэлгүүр, “Эх хошуут” ХХК-ны Оргил дэлгүүр, “Эмтийн ширээ” ХХК-ны Мандах дэлгүүрүүдэд татварын албаны хугацаатай шаардлага гардуулж, дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх, гарсан үед Зөрчлийн тухай хуулийн 11.19-ийн 12.1.⁴, 12.2.⁵ дахь заалтуудын дагуу арга хэмжээ авч ажиллахыг зөвлөлөө.

Дундговь аймгийн хэмжээнд НӨАТУС-д НӨАТ төлөгчид 100 хувь, НӨАТ төлөгч бус иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 40.6 хувьтай хамрагдсан боловч төлбөрийн баримтыг бүрэн олгохгүй байна.

1.2 Илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудын хүсэлтийг хууль, журмын дагуу хянаж баталгаажуулсан байна.

“Дүншли” ХХК НӨАТ-ын илүү төлөлт 2.3 сая төгрөгийг буцаан авах хүсэлтээ 2015 онд гаргасан байна. Хүсэлтийн дагуу аймгийн Татварын хэлтэс 2014 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хоорондох нэмэгдсэн өртгийн албан татварын ноогдуулалт, төлөлтийг санхүүгийн баримтуудад үндэслэн шалгаж, актаар баталгаажуулжээ.

“Зотол мандал” ХХК 2016 онд НӨАТ-ын илүү төлөлт 1.4 сая төгрөгийг буцаан авах хүсэлт гаргасан. Татварын хяналт шалгалтаар Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.1.1, 18.1.14-д заасныг болон бусад хуулийг зөрчиж, нийт 14.4 сая төгрөгийн зөрчил илэрч, мөн хуулийн 33.2.2, 34, НӨАТ-ын тухай хуулийн 17.3 заалтыг үндэслэн 1.4 сая төгрөгийн нөхөн татвар, 0.5 сая төгрөгийн торгууль, 0.004 сая төгрөгийн хүү, нийт 1.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна. /Хавсралт 5/


1.3 Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт хэрэгжиж эхэлснээр НӨАТ-ын төсвийн орлого өмнөх оноос 78.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр нэмэгдсэн өртгийн албан татварын босго 10.0 сая төгрөгөөс 50.0 сая төгрөг болж өссөн. Үүнтэй холбоотой НӨАТ төлөгчдийн тоо 2015 - 2016 онд 25 хувиар буурсан. /Хүснэгт 1/

⁴ бэлэн мөнгөний бүртгэлийн тасалбар олгоогүй бол тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн хоёр хувь;

⁵ бэлэн мөнгөний тасалбарыг борлуулалтын үнийн дүнгээс зөрүүтэй олгосон бол тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно

График 1. Төсвийн гүйцэтгэл



Гэтэл Татварын хэлтэс 2016 онд улсын төсөвт 10,564.5 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлсний 5.6 хувь буюу 592.1 сая төгрөгийн орлого нэмэгдсэн өртгийн албан татвараас төвлөрсөн байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад 78.2 сая төгрөгөөр нэмэгджээ. /График1/

НӨАТ төлөгчдийн тоо буурсан ч НӨАТ-ын орлого нэмэгдэж, төсвийн орлогыг тэр хэмжээгээр өсгөсөн байна.

Хүснэгт 3. НӨАТ төлөгчдийн дэлгэрэнгүй судалгаа

Судалгаанаас харахад НӨАТУС хэрэгжиж эхэлснээр НӨАТ төлөгч иргэний тоо өмнөх оноосоо 3 дахин өссөн байна. Хуулийн дагуу иргэд НӨАТУС-д хамрагдсанаар орлогоо үнэн зөв тодорхойлж далд эдийн засгийг ил болгоход ихээхэн нөлөө үзүүлж байна. Гэсэн хэдий ч жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхэлдэг иргэдийг НӨАТУС-д бүрэн хамруулж чадахгүй байна.

Хариуцлагын хэлбэр	Босго давсан		Сайн дураар	
	2016	2017	2016	2017
Иргэн	2	6		
ХК	3	2		
ХХК	107	94	60	61
Хоршоо	8	6	4	4
ОНӨААТҮГ	11	12	1	1
Нийт	131	120	65	66

Бүлэг 2. НӨАТУС-ыг нэвтрүүлээгүй албан татвар төлөгчдөд хариуцлага тооцож, арга хэмжээ авах эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байна.

2.1 НӨАТУС-ийг нэвтрүүлээгүй татвар төлөгчдөд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцох, арга хэмжээ авах журам, заавар, маягыг батлаж өгөөгүй байна.

Татвартай холбоотой гомдлыг Татварын ерөнхий газрын мэдээлэл зөвлөгөө өгөх тусгай дугаар 1800-1288, аймгийн өргөдөл гомдлын 7059106 дугаарууд хүлээн авч аймгийн Татварын хэлтэст шилжүүлдэг байна.

2016 онд НӨАТ-тэй холбоотой 3 гомдол ирсний нэг гомдол Луус суманд, хоёр нь Сайнцагаан суманд цахим төлбөрийн баримт өгөхгүй байна гэсэн гомдол иржээ.

График 2. Өргөдөл гомдлын судалгаа



2017 оны эхний хагас жилийн байдлаар НӨАТ-тай холбоотой 12 гомдол ирснээс 6 гомдол Сайнцагаан суманд, 4 гомдол Дэлгэрцогт сумын дэлгүүрүүд цахим төлбөрийн баримт олгоогүй гэсэн гомдлууд байна. Гомдлын дагуу татварын улсын байцаагч Татварын ерөнхий хуулийн 33.2.3.⁶-д заасны дагуу зөрчлийг арилгах хугацаатай шаардлага хүргүүлж ажилласан байна.

Аудитын явцад хөдөө сумдаас ирсэн гомдол гаргагч нартай холбоо барьж зөрчил арилсан эсэхийг лавлахад сумдын жижиглэн худалдаа эрхэлдэг дэлгүүрүүд хэрэглэгчийн шаардлагаар л баримт өгдөг, зарим дэлгүүрүүд бэлэн мөнгөний машин эвдэрсэн, засвартай байгаа гэсэн шалтгаанаар баримт өгдөггүй гэсэн тайлбар өгөв. Татварын байцаагч нар гомдлын дагуу газар дээр нь очиж, зөрчил гаргасан татвар төлөгч нарт зөрчлийг арилгах татварын албаны хугацаатай шаардлага өгч байна. Зөрчлийн тухай хуулийн /2017.07.01-ээс мөрдөж эхэлсэн/ дагуу стандартын бэлэн мөнгөний машин хэрэглээгүй, төлбөрийн баримт олгохгүй байгаа, үнийн дүн зөрүүтэй баримт олгосон татвар төлөгчдөд хариуцлага тооцож, арга хэмжээ авах ёстой боловч хуулийг хэрэгжүүлэх журам, заавар, маягт нь батлагдаж ирээгүй байна.

2.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт, буцаан олголтын талаар Татварын маргаан таслах зөвлөлд хандсан асуудал 2015, 2016 онуудад гараагүй байна.

Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 3.5⁷ дахь заалт, Татварын ерөнхий газрын даргын 283 тоот тушаалыг үндэслэн 2013 онд Дундговь аймгийн Татварын хэлтсийн дарга 7 хүний бүрэлдэхүүнтэй татварын маргаан таслах зөвлөлийг байгуулжээ.

Татварын төлөвлөгөөт хяналт шалгалтаар 2016 онд 98 аж ахуйн нэгж, байгууллага шалгаснаас 79.5 хувь буюу 78 НӨАТ төлөгч байгууллагыг шалгаж, 41.8 сая төгрөгийн 33 төлбөрийн акт тогтоосон байна. /Хавсралт4/ Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт, буцаан олголтын талаар 2015 болон 2016 онд Татварын маргаан таслах зөвлөлд хандсан өргөдөл, гомдол ирээгүй байна.

⁶ татварын хууль тогтоомжийг зөрчихөд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах зорилгоор шаардлага бичих бөгөөд түүнд татварын албаны даргын, эсхүл татварын улсын байцаагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, гарын үсэг, зөрчлийн тухай тэмдэглэл, зөрчил гарахад нөлөөлсөн нөхцөл, шалтгааныг арилгаж, хариу өгөх хугацаа, уг шаардлагыг үйлдсэн болон гардуулсан он, сар, өдрийг тусгана;

⁷ Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийг дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн татварын хэлтэс, газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийг 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр Үндэсний татварын ерөнхий газрын дарга тус тус батална.

Ä-ÄÍ ÝËÒ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Дундговь аймгийн хэмжээнд НӨАТУС-д НӨАТ төлөгчид 100 хувь, НӨАТ төлөгч бус иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 40.6 хувьтай хамрагдсан ч төлбөрийн баримтыг бүрэн олгохгүй байна.
2. Илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хууль, журамд заасны дагуу хянаж, баталгаажуулсан байна.
3. НӨАТУС хэрэгжиж эхэлснээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд орлогоо үнэн зөв тодорхойлох, далд эдийн засгийг ил болгоход нөлөө үзүүлжээ.
4. Зөрчлийн тухай хуулийн дагуу татварын улсын байцаагч арга хэмжээ авах журам, заавар, маягт нь батлагдаагүйгээс хариуцлага тооцох боломжгүй байна.
5. Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт, буцаан олголтын талаар 2015 болон 2016 онд Татварын маргаан таслах зөвлөлд хандсан өргөдөл, гомдол ирээгүй байна.

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГЭХ САНАЛ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах саналыг Татварын ерөнхий газарт хүргүүлэхээр ҮАГ-т уламжилж байна. Үүнд:

1. Татварын улсын байцаагч НӨАТУС-ийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцох, арга хэмжээ авах журам, заавар, маягтыг батлаж өгөх.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллагад зөвлөж байна. Үүнд:

Дундговь аймгийн татварын хэлтэст:

1. Цахим төлбөрийн баримт олголтод хяналт тавьж, НӨАТУС-ийн мэдээлэл сурталчилгааг иргэдэд тогтмол хүргэж байх;
2. Аймгийн жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхэлдэг иргэдийг НӨАТУС-д бүрэн хамруулах.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн ачаагийн үйлчилгээний 19 дүгээр зүйлийн 19.3.1-д заагдсан аргаар ачаагийн үйлчилгээний төрийн аудитын газар 2017 оны 9-р сарын 18-ны өдөр аймагын Татварын хэлтэст ажил хэрэгээр явуулж, түүнийг үнэлж, үнэлгээний тайланг үргэлжлүүлж авлаа.



ДУНДГОВЬ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТЭС

48090 Мандалговь, Сайнцагаан сум
Утас, Факс: 7059-3033,
E-mail: dundgobi@mta.mn

2017-09-26 № 08/421
танай 2017-09-18 -ны № 173 -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн Аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой санал байхгүй болно.

ОРЛОГЫН ТАСГИЙН
ДАРГА ТУАБ

Н.МӨНГӨНТУЯА

С. Салтмаг

Аймагын татвар,
үзэгнүүр байр,
төрийн аудитын газар
2017/09/22

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/20

Мандалговь

Г Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалын хавсралтын 5 дугаар заалт, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /УАГ-ГАГ/2017/08-ГА/-г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага, зөвлөмж)-ыг хавсралтаар баталсугай.
3. “Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Татварын хэлтэст тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2017 оны 12 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Татварын хэлтсийн дарга /М.Туяацэцэг/-т зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, гүйцэтгэлийн аудитын багийн аудитор /Д.Должинсүрэн/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ОЮУНЧИМЭГ



D:\office\Tushaal\A4\VAT report batalgajuuлах tuhаi.docx

0000000022



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын
төрүүлэх аудиторын 2017 оны 1 дүгээр сарын
18-ны өдрийн А/Дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Аудитын код: УАГ-ГАГ/2017/08-ГА

Аудитын нэр: "Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн"
сая төгрөгөөр

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсэн хуулийн заалт	Зөрчлийн дүн мян.төг	Үүнээс					Үр өгөөжийн	
				Аудитын явцад баригдүүлсан	Акт тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн	Тоо	Мөнгөн дүн	
1	Барилгын материал борлуулдаг 8 дэлгүүр стандартын кассын машин суурилуулаагүй, төлбөрийн баримт хэвлэж өгөөгүй, зөрчил арилгах талаар өгсөн татварын албаны шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Дээрх зөрчилд Татварын хэлтсээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 12,000,000.00 /Арван хоёр сая/ төгрөгөөр торгох, зөрчлийг арилгах дараагийн арга хэмжээг аваагүй байна.	Татварын Ерөнхий хуулийн 18.1.8-д, Зөрчлийн тухай хуулийн 11.19-ийн 6.5-д	12.0			12.0		1	12.0	
2	Цахим төлбөрийн баримт олголтод хяналт тавьж, НӨАГУС-ын мэдээлэл сурталчилгааг иргэдэд тогтмол хүргэж байх;	Татварын Ерөнхий хуулийн 15.1.5., 22.1.1								
3	Аймгийн жижигтэнгийн худалдаа, үйлчилгээ эрхэлдэг иргэдийг НӨАГУС-д бүрэн хамруулах.	Татварын Ерөнхий хуулийн 18.1.8-д								
Дүн				12.0	-	12.0	-	1	12.0	

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Хавсралт №1

Дундговь аймгийн Улсын бүртгэл болон Татварын хэлтэст бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын харьцуулсан судалгаа

2015 он									
№	Хуулийн этгээдийн төрөл	Эхний үлдэгдэл		Нэмэгдсэн		Хасагдсан		Үлдэгдэл	
		Татвар	Улсын бүртгэл	Татвар	Улсын бүртгэл	Татвар	Улсын бүртгэл	Татвар	Улсын бүртгэл
1	ӨЁ	4	4					4	4
2	ӨӨЁ	424	448	57	51	4		477	499
3	БГБХН	5		2				7	0
4	Өй дөйй	95	93	2	1	2		95	94
5	Өаагаламж сүүеёёй ой дөйй	10						10	0
6	Ө - А	1	1					1	1
7	Ий а ААТ - А	18	18					18	18
	Иёёо:	557	564	59	52	6	0	612	616
2016 он									
№	Хуулийн этгээдийн төрөл	Эхний үлдэгдэл		Нэмэгдсэн		Хасагдсан		Үлдэгдэл	
		Татвар	Улсын бүртгэл	Татвар	Улсын бүртгэл	Татвар	Улсын бүртгэл	Татвар	Улсын бүртгэл
1	ӨЁ	4	4					4	4
2	ӨӨЁ	477	499	33	33	7	19	503	513
3	БГБХН	7	0	2				9	0
4	Өй дөйй	95	94		2	3	7	92	89
5	Өаагаламж сүүеёёй ой дөйй	10	0			2		8	0
6	Ө - А	1	1					1	1
7	Ий а ААТ - А	18	18					18	18
	Иёёо:	612	616	35	35	12	26	635	625

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн судалгаа /сая.төг/

№	Орон нутаг	2014 оны жилийн эцсийн НӨАТ суутган төлөгч		2015 он						2015 оны жилийн эцсийн НӨАТ суутган төлөгч	
				шинээр нэмэгдсэн				хасагдсан			
				НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлж, гэрчилгээ авсан		Сайн дураар НӨАТ төлөгчөөр бүртгүүлж, гэрчилгээ авсан		НӨАТ суутган төлөгчөөс хасагдсан			
Хувь хүн	Хуулийн этгээд	Хувь хүн	Хуулийн этгээд	Хувь хүн	Хуулийн этгээд	Хувь хүн	Хуулийн этгээд	Хувь хүн	Хуулийн этгээд		
1	Дундговь	3	262		10		2		10	3	260

2015 оны жилийн эцсийн НӨАТ суутган төлөгч		2016 он								2016 оны жилийн эцсийн НӨАТ суутган төлөгч	
		шинээр нэмэгдсэн				хасагдсан					
		НӨАТУС бүртгүүлсэн албан татвар төлөгч		НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлж, гэрчилгээ авсан		Сайн дураар НӨАТ төлөгчөөр бүртгүүлж, гэрчилгээ авсан		НӨАТ суутган төлөгчөөс хасагдсан			
Хувь хүн	Хуулийн этгээд	Хувь хүн	Хуулийн этгээд	Хувь хүн	Хуулийн этгээд	Хувь хүн	Хуулийн этгээд	Хувь хүн	Хуулийн этгээд	Хувь хүн	Хуулийн этгээд
3	260	108	43	2	4	1		3	71	2	194

Хавсралт №3

Худалдан авалтын НӨАТ-ын буцаан олголт, сугалааны тохирлын судалгаа

Он	НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн		Үүнээс: худалдан авалтыг нотлох баримт олгодог		Худалдан авалтын баримт олголттой холбоотой ирүүлсэн гомдол, шийдвэрлэлт								500000 төгрөгөөс дээш хонжвор хожсон		Хянаж баталгаажуулсан	
	Иргэн /тоогоор/	Аж ахуйн нэгж, байгууллага /тоогоор/	Иргэн /тоогоор/	Аж ахуйн нэгж, байгууллага /тоогоор/	Баримт олгоогүй /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/	Гомдлыг шийдвэрлэсэн /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/	олгосон баримтын дүн зөрүүтэй /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/	гомдлыг шийдвэрлэсэн /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/	Иргэн ээс ирүүлсэн хүсэлт /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/	баталгаажуулсан хүсэлт /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/
2016	2	194	2	189	3		3					5	2,500,000	5	2,500,000	
2017	6	180	6	182	15		12					3	1,500,000	3	1,500,000	

Хавсралт №4

Татварын хяналт шалгалт болон маргаан таслах ажиллагааны талаарх судалгаа

Он	Төлөвлөгөөт хяналт, шалгалтын тоо	Үүнээс: Шалгалтад хамрагдсан НӨАТ төлөгчийн тоо	Хяналт шалгалтаар тогтоогдсон		Үүнээс: НӨАТ-тай холбоотой хяналт шалгалтаар тогтоогдсон		Маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан		Маргаан таслах зөвлөлийн шийдвэр	
			актын тоо	мөнгөн дүн /мянган төгрөгөөр/	актын тоо	мөнгөн дүн /мянган төгрөгөөр/	актын тоо	мөнгөн дүн	байцаагчийн талд шийдвэрлэгдсэн актын тоо	мөнгөн дүн
2015	109	39	36	32,062.8	16	21,009.0				
2016	98	78	70	108,851.9	33	41,827.7				

Хавсралт №5

Татварын хяналт шалгалт болон маргаан таслах ажиллагааны талаарх судалгаа

Он	Илүү төлсөн НӨАТ-аа буцаан авах хүсэлт гаргасан				Буцаан олгосон НӨАТ				Татварын алба хянаж, актаар баталгаажуулсан				Шалгалтаар илэрсэн дутуу төлөлтөд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэсэн			
	Иргэн /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/	ААНБ /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/	Иргэн /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/	ААНБ /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/	илүү төлөлт /актын тоо/	мөнгөн дүн /мян.төг/	дутуу төлөлт /актын тоо/	мөнгөн дүн /мян.төг/	Торгууль /тоогоор/	мөнгөн дүн /мян.төг/	Тогтоосон хүү /мян.төг/	Тогтоосон алданги /мян.төг/
2015			1	2,367.2						2,367.2						
2016			1	1,401.7							1	1,440.2	1	462.3	4.3	0